



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 05 сарын 17 өдөр

Дугаар 1193

Хэрлэн сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.3-ын "б", Ашигт малтмалын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1 дэх заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 9 дүгээр сарын 21-ний өдрийн 02 дугаар тогтоолоор баталсан аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын Тамгын газар, Швейцарийн хөгжлийн агентлагийн хамтран хэрэгжүүлж буй "Тогтвортой бичил уурхай" төслийн хүрээнд хариуцлагатай бичил уурхайг хөгжүүлэх, зохион байгуулалтад оруулж албажуулах, орон нутгийн эдийн засагт оруулж буй хувь нэмрийг тооцон, холбогдох байгууллагууд хамтран тодорхойлж, 2018 оны үйл ажиллагааны үндсэн чиглэл, төлөвлөгөөнд тусгах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн
ахлагч:

-Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга

Гишүүд:

-Хөрөнгө оруулалт, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга

-Хууль, эрх зүйн хэлтсийн дарга

-Хүүхэд, гэр бүл, залуучуудын хөгжлийн газрын дарга

-Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтсийн дарга

-Байгаль орчин, аялал жуулчлалын газрын уул уурхай хариуцсан мэргэжилтэн

-Мэргэжлийн хяналтын газрын байгаль орчны хяналтын улсын байцаагч

-Татварын хэлтсийн орлогын тасгийн дарга

-Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн захирал

- "Ажил олгогч эздийн холбоо" ТББ-ын тэргүүн

Нарийн бичгийн
дарга:

-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн хөдөө аж ахуй, байгаль орчны бодлого хариуцсан мэргэжилтэн

01 962

2//.

2. Бичил уурхайн үйл ажиллагааг орон нутагт бэхжүүлэх, орон нутаг бичил уурхайн хувь нэмрийг бодитоор үнэлэх, орон нутгийн эдийн засгийн хөгжилд татан оруулах бодлогын саналуудыг томъёолж, холбогдох мэргэжлийн байгууллагуудын ажлын уялдаа холбоог ханган 2018 оны үйл ажиллагааны үндсэн чиглэл, төлөвлөгөөнд тусгах ажлыг зохион байгуулж 2017 оны 12 дугаар сарын 15-ны дотор тайлагнахыг ажлын хэсгийн ахлагч, аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Ж.Ганбаатар/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА